



БАТАЛГААЖУУЛСАН:  
“Монголын Барилгын Зураг Төсөл  
Зохиогчдын Холбоо”-ны Ерөнхийлөгч

Я.СҮМХҮҮ

МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН  
ХОЛБООНЫ ДҮРЭМ

“Монголын Барилгын Зураг Төсөл  
Зохиогчдын Холбоо”-ны 2023.01.24.  
ний өдрийн Бүх гишүүдийн хурлаар  
батлав.



НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 “МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБОО” (цаашид “Холбоо” гэх) нь Монгол Улсын “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, олон улсын нийтлэг жишигийг баримталсан төрөөс хараат бус, үйл ажиллагаа нь олон улсын нийтэд ил тод, өөрийгөө санхүүжүүлэн энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллах, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус, мэргэжлийн байгууллага мөн.
- 1.2 Холбооны албан ёсны оноосон нэр:
  - 1.2.1. Монгол хэлээр: МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБОО Цаашид “МБЭТЗХ” ТББ гэж товчилж бичнэ.
  - 1.2.2 Англи хэлээр: MONGOLIAN ASSOCIATION OF CONSTRUCTION DESIGNERS Цаашид “MACD” NGO гэж товчилж бичнэ.
- 1.3 Албан ёсны хаяг:

Холбоо нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж, 45/4-р байр 404; 402 тоот. ЗИП КОД 16050  
Харилцах утас 976-77113136; 80091155
- 1.4 Холбоо нь 2007 оны 06 дугаар сарын 07-ны өдөр үүсгэн байгуулагдсан.
- 1.5 Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо нь хуулийн этгээдийн эрх эдэлж, энэхүү дүрмийн Хавсралт 1-д заасан бэлгэ тэмдэг (лого), тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банк санхүүгийн байгууллагад харилцах данстай байна.
- 1.6 Холбоо нь гишүүн байгууллага болон гишүүндээ эрх тэгш үйлчлэх бөгөөд аливаа хэлбэрээр ялгavarлан гадуурхахыг хориглоно.
- 1.7 Орон нутагт салбар, төлөөлөгчтэй байж болно. Мөн үйл ажиллагааг төрөлжүүлж клубтэй байж болно.



## ХОЁР. Зорилго, үйл ажиллагааны чиглэл

### 2.1 Холбооны алсын хараа нь:

Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн салбарын манлайлагч төрийн бус, мэргэжлийн байгууллага байна.

### 2.2 Холбооны эрхэм зорилго нь:

Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогыг төр болон төрийн бус, мэргэжлийн байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар хэрэгжүүлэх, зураг төслийн ажлыг олон улсын жишигт хүргэх, төрийн ногоон хөгжлийн бодлогыг дэмжих, гишүүн байгууллагын түвшинг инженер, техникийн ажилчдын чадавхийг хөгжүүлэх, мэдээллээр хангаж эрх ашигийг хамгаалахад оршино.

### 2.3 Холбоо нь эрхэм зорилгоо биелүүлэхэд чиглэсэн дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

2.3.1 Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод санал өгөх, төр болон төрийн бус байгууллагын түншлэл хөгжүүлэх замаар гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах;

2.3.2 Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарын хууль эрх зүйн баримт бичиг, нормативын баримт бичгийг сайжруулах замаар салбарын шинэ мэдээ мэдээллээр хангах, мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.3.3 Холбооны үйл ажиллагааг тогтвортой явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх замаар бий болгох;

2.3.4 Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарт гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, төрийн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагад гэрээгээр гүйцэтгэх, бусад төрийн бус, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг дээшлүүлэх;

2.3.5 Гишүүн байгууллагуудын нийгмийн идэвхи, урлаг, соёл, спортыг хөгжүүлэхэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

### 2.4 Холбоо нь эрхэм зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

2.4.1 Салбарын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлж, үнэлэлт, дүгнэлт өгөх,

2.4.2 Хот байгуулалт, барилгын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг түншлэлийн гэрээгээр хамтран гүйцэтгэх, мэргэжилтэй ажилтны давтан болон чадавхижуулах сургалтыг эрхлэх;

2.4.3 Зураг төслийн холбогдолтой хууль, тогтоомж, барилгын норм ба дүрэм, стандарт боловсруулахад оролцох, түүнийг хэрэгжүүлэх;

2.4.4 Зураг төслийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, үндэсний зөвлөх үйлчилгээний байгууллагуудыг төлөвшүүлэх, гадаад орны зураг төсөлчидтэй хамтран ажиллах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг/

- 2.4.5 Зураг төслийн байгууллагуудын инженер, техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;
- 2.4.6 Зураг төслийн салбарын мэдээ, мэдээлэл цуглуулах, солилцох түгээх, мэдээллийн сан байгуулан үйл ажиллагаандаа ашиглах;
- 2.4.7 Зураг төслийн үйлдвэрлэлд шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг нэвтрүүлэх, мэдээллээр хангах, хууль эрх зүй, мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- 2.4.8 Зураг төсөл боловсруулах, хянаж зөвшөөрөлцөх, магадлал хийх, ажлын шат дамжлагыг багасгах чиглэрээр санал, зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллагуудад тавих;
- 2.4.9 Барилга байгууламжийн угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт хийх, байнгын ашиглалтанд оруулахтай холбогдсон барилгын норм дүрэм, эрх зүйн баримт бичиг, төсөлд саналаа өгөх;
- 2.4.10 Зураг төсөлчдийн залгамж халаа хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх ажлыг холбогдох гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
- 2.4.11 Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, энэхүү үйл ажиллагаандаа гишүүн байгууллага, гишүүдийг оролцуулж, нэгдсэн зохион байгуулалтын удирдлагаар хангах;
- 2.4.12 Төрийн болон гүйцэтгэх засаглалын байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэх;
- 2.4.13 Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хурал, семинар, уулзалт, хэвлэлийн бага хурал, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;
- 2.4.14 Гишүүн байгууллага, гишүүдийнхээ ажил, бүтээлд үнэлгээ өгөх, шалгаруулалт хийх, төр засгийн шагналд тодорхойлох;

#### **ГУРАВ. Холбооны бүтэц, хяналтын тогтолцоо**

- 3.1 Холбооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал бөгөөд бүх гишүүдийн хурлуудын хооронд холбооны удирдлагыг Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх алба хэрэгжүүлнэ.
- 3.2 Бүх гишүүдийн хурал
  - 3.2.1 Бүх гишүүдийн ээлжит хурлыг жил тутам нэгдүгээр улиралд зохион байгуулна. Бүх гишүүдийн хуралдааныг Хурлаас сонгогдсон хурлын тэргүүлэгчид удирдана. Хурлын шийдвэрийг олонхийн саналаар гаргах бөгөөд хурлын тогтоолд тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажуулна.
  - 3.2.2 Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг Удирдах зөвлөлийн дийлэнхи олонхи (2/3)-ийн санал гаргасан эсхүл холбооны Ерөнхийлөгчийн санаачлагаар зарлан дор дурьдсан асуудлаар хуралдуулж болно. Үүнд:
    - 3.2.2.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөлд нөхөн батлах;
    - 3.2.2.2 Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг нөхөн батлах;
    - 3.2.2.3 Бүх гишүүдийн хурлын эрх мэдэлд хамааралтай асуудлаар цаг үеийн чухал шийдвэрийг гаргуулах.
  - 3.2.3 Бүх гишүүдийн хурлыг гишүүн байгууллагын 51 ба түүнээс дээш хувь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг /



- 3.2.4 Онцгой нөхцлийн улмаас Бүх гишүүдийн хурал хойшлогдсон тохиолдолд дараагийн сонгууль хүртэлх хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж буй албан тушаалтнууд бүрэн эрхээ тодорхой бус хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.5 Бүх гишүүдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.2.5.1 Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
  - 3.2.5.2 Холбооны хөгжлийн Стратеги төлөвлөгөө батлах;
  - 3.2.5.3 Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд үнэлэлт өгөх;
  - 3.2.5.4 Холбооны хяналтын зөвлөлийн тайланд үнэлэлт өгөх;
  - 3.2.5.5 Холбооны Удирдах Зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч (цаашид “Ерөнхийлөгч” гэх) болон холбооны Дэд ерөнхийлөгч нарыг (цаашид “Дэд ерөнхийлөгч” гэх) сонгох;
  - 3.2.5.6 Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох;
  - 3.2.5.7 Гишүүнчлэлийн татварын хэмжээг тогтоох;
  - 3.2.5.8 Холбооны зүгээс тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэх
  - 3.2.5.9 Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах болон үлдэгдэл хөрөнгийг хуваарилах асуудлыг шийдвэрлэх;
  - 3.2.5.10 Салбар болон Мэргэжлийн хороо, клубын бүтэц бүрэлдэхүүн, ажиллах журмын төсөлтэй танилцах;
  - 3.2.5.11 Удирдах зөвлөлөөс оруулсан бусад асуудлууд;

### 3.3 Удирдах зөвлөл

- 3.3.1 Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа нь хуралдааны хэлбэр байх бөгөөд хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 3.3.1.1 Холбооны үндсэн үйл ажиллагааны биелэлтээр Бүх гишүүдийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлэх;
  - 3.3.1.2 Холбооны жилийн төсөв, орон тооны бүтцийг батлах;
  - 3.3.1.3 Холбооны тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
  - 3.3.1.4 Бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэр болон холбооны эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх
  - 3.3.1.5 Холбооны гүйцэтгэх захирал болон менежерүүдийг томилох, тэдгээртэй байгуулсан гэрээг дүгнэх, жилийн ажлын тайланг хэлэлцэх, ажлаас чөлөөлөх асуудал;
  - 3.3.1.6 Холбооны үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай дүрэм, журам, зааврыг санаачлан батлах, мөрдүүлэх;
  - 3.3.1.7 Холбооны өмч, хөрөнгийг захиран зарцуулах болон бусад шийдвэр гаргах талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох;
  - 3.3.1.8 Шинээр гишүүнээр элсэх хүсэлтээ гаргасан байгууллага, хүмүүсийг гишүүнд элсүүлэх, батламжлах эсхүл гишүүн байгууллага, гишүүнийг хасах;
  - 3.3.1.9 Бусад орнуудын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл, ОУ-ын байгууллагуудын гишүүн байгууллага болох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
  - 3.3.1.10 Холбооны орон нутгийн салбар, клубын ажиллах дурмийг батлах;

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав/

/Д.Гантулга/

/С.Алтанцэцэг/



- 3.3.1.11 Удирдах зөвлөлийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын хууль бус үйл ажиллагаа, ажлын хариуцлага алдсанаас үүссэн хохирол, бусад байгууллагуудад төлөх торгууль, төлбөрийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 3.3.1.12 Дүрэмд заагдсан бусад эрх, үүрэг.
- 3.3.2 Холбооны Удирдах зөвлөл нь 9 болон түүнээс дээш сондгой тооны гишүүнтэй, Хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүд нь үүрэг даалгавраа гүйцэтгэх явцад гарсан нөхөн төлбөрөөс өөр бусад цалин, шагнал авахгүй.
- 3.3.3 Холбооны Удирдах Зөвлөлийн хуралдаан нь тухайн жилийн Удирдах зөвлөлийн гишүүдийн олонх дэмжиж Холбооны Ерөнхийлөгчийн албажуулсан хурлын дэгийг баримталж ажиллана.
- 3.3.4 Холбооны Удирдах зөвлөлийн хурлыг улирал тутам хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлийн даргын санаачлагаар зарлан хуралдуулж болно.
- 3.3.5 Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн дарга сонирхлын зөрчилтэй байвал тухайн хурлаас хуралдаан даргалагчийг сонгоно.
- 3.3.6 Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Холбооны Ерөнхийлөгчийг бүх гишүүдийн хурлаар 3 (гурван) жилийн хугацаатайгаар сонгоно. Нэг удаа улиран сонгогдож болно.
- 3.3.7 Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх нөхөн сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ дараах зарчмыг баримтална.
- 3.3.7.1. Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх нөхөн сонгох асуудлыг Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн жил бүр ажиллах бүрэлдэхүүнд 30 хүртэлх хувьд өөрчлөлт оруулна;
- 3.3.7.2 Удирдах зөвлөлийн гишүүд нь мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан нь баримтаар нотлогдсон;
- 3.3.7.3 Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ;
- 3.4. Холбооны ерөнхийлөгч
- 3.4.1 Ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байна
- 3.4.2 Ерөнхийлөгч нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
- 3.4.2.1 Удирдах, манлайлах ур чадвартай;
- 3.4.2.2 Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн;
- 3.4.2.3 Ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын зөрчил гаргаж байгаагүй;
- 3.4.2.4 Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан байх;
- 3.4.3 Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.4.3.1 Удирдах Зөвлөлийн шийдвэрээр Бүх гишүүдийн хурлыг хуралдуулах;
- 3.4.3.2 Холбооны үйл ажиллагааны урт хугацааны болон дунд хугацааны Хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлж, Удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах;
- 3.4.3.3 Холбоог гадаад, дотоодод төлөөлөх;

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг/

- 3.4.3.4 Төр засгийн байгууллага болоод бусад Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- 3.4.3.5 Хэвлэл мэдээллээр мэдэгдэл хийх;
- 3.4.3.6 Удирдах Зөвлөлийн хурлыг даргалах;
- 3.4.3.7 Удирдах Зөвлөлийн шийдвэрийн дагуу гүйцэтгэх захидалтай гэрээ байгуулах;
- 3.4.3.8 Өмнөх Ерөнхийлөгч нь сонгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэгч Ерөнхийлөгчид эхний 2 хүртэл жилд зөвлөж ажиллах;

#### 3.4.4 Ерөнхийлөгч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.4.4.1 Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах;
- 3.4.4.2 Удирдах Зөвлөлийн гишүүнийг эргүүлэн татах нөхцөл бүрдсэн тохиолдолд асуудлыг Удирдах Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэх;

#### 3.5. Дэд ерөнхийлөгч

- 3.5.1 Холбоо нь Бодлого төлөвлөлт, Дотоод үйл ажиллагаа хариуцсан 2 дэд ерөнхийлөгчтэй байна. Удирдах зөвлөлийн гишүүд Дэд ерөнхийлөгчид өөрийгөө болон бусад гишүүдийг нэр дэвшүүлэх бөгөөд бүх гишүүдийн олонхийн саналаар сонгогдоно.
- 3.5.2 Дэд ерөнхийлөгч нар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 3.5.2.1 Дотоод үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч нь Холбооны Гүйцэтгэх албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах
  - 3.5.2.2 Дотоод үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч нь орон нутаг дахь Салбар, клубийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжих, чиглүүлэх.
  - 3.5.2.3 Бодлого төлөвлөлт хариуцсан Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн эзгүйд орлон гүйцэтгэх бөгөөд зураг төслийн салбарын бодлого чиглэлийг сайжруулах, холбооны бодлогын зөвлөлтэй хамтран ажиллах;
- 3.5.3 Хариуцан ажиллаж байгаа чиглэлээрээ мэдээ мэдээлэл цуглуулан судалж, дүгнэлт гаргаж Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлд танилцуулах;
- 3.5.4 Удирдах зөвлөл болон Ерөнхийлөгчийн хариуцуулсан мэргэжлийн хороодыг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж хамтран ажиллах, бодлогын зөвлөлийг уялдуулах


#### 3.6 Хяналтын зөвлөл

- 3.6.1 Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон Хяналтын зөвлөл нь холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, байгуулсан гэрээ, хэлцэл нь энэхүү дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.6.2 Холбооны үйл ажиллагаа Монгол Улсын хууль, тогтоомж, энэхүү дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянах;
- 3.6.3 Нягтлан бодох бүтгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, гишүүдийн татвар, хураамжийн төлөлт зо хих хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэхийг шалгах;
- 3.6.4 Гишүүн байгууллагын татвар төлөлт, хандивын хөрөнгө, бусад орлогын хэмжээ, зарцуулалтанд хяналт тавих;
- 3.6.5 Шаардлагатай үед бусад байгууллага, иргэдтэй хийсэн гэрээ, хэлцэлийн биелэлт болон гадаад харилцаатай холбогдол бүхий баримт бичгийг шалгах;

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

 /Б.Бямбажав /  
 /Д.Гантулга /  
 /С.Алтанцэцэг/



- 3.6.6 Гишүүн байгууллагаас Хяналтын зөвлөлд тодорхой асуудлаар гомдол гаргавал шалгаж, дунг Удирдах зөвлөлд танилцуулах;
- 3.6.7 Хяналтын зөвлөл шалгасан баримт бичиг, тайлан тэнцлийн нууцыг хадгалах үүрэгтэй;
- 3.6.8 Гүйцэтгэх захирлаас шалгалтын ажилтай холбоотой материалыг шаардаж гардуулах эрхтэй;
- 3.6.9 Хяналтын зөвлөл нь бүх гишүүдийн хуралдаанд ажлын тайлан тавина. Тайланд дараагийн жилд авах арга хэмжээний саналыг тусгана.
- 3.6.10 Хяналтын зөвлөл нь өөрийн мэдлэг чадвар хүрэхгүй ажил дээр мэргэжлийн үйлчилгээ авах, аудит оруулах шаардлагатай тохиолдолд чиг үүрэгт хамаарах асуудлаар мэргэжлийн хуулийн этгээд, хувь хүн, шинжээч хөлслөн авах эрхтэй байна;

### 3.7 Гүйцэтгэх алба

- 3.7.1 Гүйцэтгэх алба нь Холбооны эрхэм зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ
- 3.7.2 Холбоо гүйцэтгэх албатай байх ба гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх албыг удирдана;
- 3.7.3 Гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөл сонгон шалгаруулалтаар томилж, Ерөнхийлөгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана;
- 3.7.4 Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан "Холбооны хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах;
- 3.7.5 Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах;
- 3.7.6 Гүйцэтгэх захирал тухайн жилийн төлөвлөгөөг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж, төлөвлөгөө болон төсвөө Удирдах зөвлөлийн хурлаар батлуулж ажиллана;
- 3.7.7 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд Гүйцэтгэх захирал нь холбоог төлөөлөх, батлагдсан төсөв төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө захиран зарцуулна;
- 3.7.8 Гүйцэтгэх захирал нь холбооны жилийн үйл ажиллагааны тайланг баталгаажуулж тогтоосон хугацаанд Төрийн эрх бүхий байгууллагад холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.
- 3.7.9 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд түүний эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлсийг харилцан тохиролцож тусгана;
- 3.7.10 Гүйцэтгэх захирал гэрээнд заасан бүрэн эрхийн хугацаа дууссан үед дараагийн гүйцэтгэх захирлыг томилогоо хүртэл албан үүргээ гүйцэтгэнэ;
- 3.7.11 Удирдах Зөвлөл жил бүрийн эхний тайлангийн хурлаар Гүйцэтгэх албаны бүтэц, орон тоо, ажилтны цалин, урамшууллын хэмжээг тогтооно.
- 3.7.12 Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийнхээ хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ, мэдээлэл, баримт бичиг, эд хөрөнгө зэргийг бүртгэлийн хамт бүрэн төгс албан ёсоор дараагийн гүйцэтгэх захиралд хүлээлгэж өгөх
- 3.7.13 Гүйцэтгэх захирал нь дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Үүнд:
  - 3.7.13.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбооны нэрийн өмнөөс хөрөнгийн баталгаа гаргах, холбооны хөрөнгөөр барьцаа тавих, зээл олгох, төлбөр төлөх,
  - 3.7.13.2. Байгууллагын дотоод мэдээлэл, нууцыг задруулах,
  - 3.7.13.3 Холбоог хуваах, өөрчлөх, нэгтгэх, нийлүүлэх зорилгоор аливаа үйл ажиллагаа явуулах,
  - 3.7.13.4 Ижил зорилго бүхий төрийн бус байгууллага байгуулах.
- 3.7.14 Холбооны менежерүүд нь Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэн батлагдсан томилогоо албан тушаалтан байх бөгөөд Гүйцэтгэх захирлын шууд удирдлаганд холбооны өдөр тутмын ажиллагааг гүйцэтгэнэ.

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулгэ /

/С.Алтанцэцэг/



### 3.8 Холбооны бодлогын зөвлөл

- 3.8.1 Холбоо нь хөгжлийн стратеги, бодлого, чиглэлийн залгамж чанарыг хадгалан хөгжүүлэх зорилгоор “холбооны бодлогын зөвлөл”-ийг байгуулж ажиллах журмыг Удирдах зөвлөл батална.
- 3.8.2 Уг Бодлогын зөвлөлийг өмнөх Ерөнхийлөгч ахална. Бодлогын зөвлөл нь холбооны ўйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллана;
- 3.8.3 Гаргах шийдвэр нь зөвлөмж байна.

### ДӨРӨВ. Холбооны гишүүнчлэл

- 4.1 Холбооны гишүүнчлэл нь холбооны дүрмийг хүлээн зөвшөөрсөн, Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн ААН байгууллагаас бүрдэнэ.
- 4.2 Холбоонд гишүүнээр элсэхийг хүссэн байгууллага, хүмүүс нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхөө илэрхийлсэн хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд холбооны Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 4.3 Гишүүн байгууллага, гишүүн нь жил бүр гишүүнчлэлийн татвараа төлөх бөгөөд татварыг жилийн эхний улиралд багтаан төлнө.
- 4.4 Холбооны гишүүн байгууллага, гишүүн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
  - 4.4.1 Холбооны удирдах албан тушаалд сонгох, сонгогдох, нэрээ дэвшүүлэх, татгалзах;
  - 4.4.2 Холбооны ўйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, гишүүдийн эрх ашгийг хамгаалах талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, зохих итгэмжлэлийн дагуу Холбоог төлөөлөх, нэр, хаягийг хэрэглэх;
  - 4.4.3 Холбооны ажлын болон санхүүгийн тайлан, бусад мэдээлэлтэй үнэ төлбөргүй танилцах, Холбооны санд байгаа мэдээллийг тогтоосон журмын дагуу авч хэрэглэх;
  - 4.4.4 Холбоонаос мэргэжлийн ўйл ажиллагаа, бутээлийнхээ батламж, тодорхойлолтыг гаргуулах, тусламж хүсэх;
  - 4.4.5 Холбоонаос зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалтанд оролцох, санал өгөх, үзэсгэлэнд бүтээлээ тавих.
- 4.5 Гишүүн байгууллага, гишүүн нь тус холбооны дүрэм, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг, даалгавар, уриалгыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, хугацаанд нь биелүүлэх үүрэгтэй.
- 4.6 Холбооны гишүүнчлэлээс дараах үндэслэлээр хасна. Үүнд:
  - 4.6.1 Байгууллагын удирдлага, хамт олон хүсэлтээ бичгээр гаргасан;
  - 4.6.2 Холбооны дүрэм, гишүүний үүргээ зөрчсөний улмаас холбооны ажил хэргийн нэр хүндийг унагаасан, хохирол учруулсан;
  - 4.6.3 Сахилгын болон мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасан;
  - 4.6.4 Гишүүнчлэлийн татвараа хүндэтгэх шалтгаангүйгээр 12 сараас дээш хугацаагаар төлөөгүй.

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг/



- 4.7 Гишүүнчлэлээс хасах шийдвэрийг Удирдах зөвлөл гаргана.
- 4.8 Гишүүнчлэлээс хасах асуудлыг шийдвэрлэхдээ гишүүн байгууллага, гишүүнд урьдчилан бичгээр мэдэгдэж, хэлэлцэх хуралд биеэр оролцон тайлбар өгөх боломжоор хангана. Хуралд оролцох талаар мэдсэн атлаа ирээгүй явдал нь асуудлыг хэлэлцэхэд саад болохгүй.
- 4.9 Гишүүнчлэлээс гарсан, хасагдсан гишүүн байгууллага, гишүүн нь гишүүний эрх, үүргийг эдлэхгүй, холбооны нэр, бэлгэ тэмдэгийг ашиглах эрхгүй бөгөөд буруутай үйлдлийн улмаас учруулсан бодит хохирлоо барагдуулах хариуцлагаас чөлөөлгөхгүй.
- 4.10 Гишүүнчлэлээс гарсан, хасагдсан байгууллага, хувь хүний тушаасан тухайн жилийн гишүүний татвар, бусад мөнгөн хандивыг эргүүлэн олгохгүй.
- 4.11 Дахин элсэх тухай хүсэлтийг шинээр элсэж буй байгууллага, хувь хүний адилаар гаргахдаа нэг жилийн гишүүний татварыг нөхөн төлсөн байна.

#### **ТАВ. Санхүүгийн үйл ажиллагаа**

- 5.1 Холбооны үндсэн ба мөнгөн хөрөнгийг зөвхөн Холбоо өөрөө эзэмшинэ. Дүрмээр заасан үйл ажиллагааг явуулахын тулд Ерөнхийлөгчийн нэр дээр бүртгүүлсэн байна.
- 5.2 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд түүнийг захиран зарцуулах эрхийг Гүйцэтгэх захирал эдэлнэ.
- 5.3 Холбооны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн дагуу явуулж, санхүүгийн жилийн тайлан, тэнцлийг гаргаж харьяалагдах татварын албанд өгнө. Тайланд дараах үндсэн, бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:
  - Баланс
  - Орлогын тайлан
  - Мөнгөн гүйлгээний тайлан
  - Хуримтлагдсан хандивын тайлан
  - Нэмэлт тайлбар тодруулга
- 5.4 Холбооны дансаар дамжих бүхий л гүйлгээний баримтанд Гүйцэтгэх захирал гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.
- 5.5 Холбооны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - 5.5.1 Гишүүн байгууллага, гишүүдийн татвар, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив;
  - 5.5.2 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого;
  - 5.5.3 Зээлийн ба өвийн хөрөнгө;
  - 5.5.4 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв болон Олон Улсын байгууллагаас олгосон хөрөнгө;
  - 5.5.5 Уран бүтээлийн үзэсгэлэн, мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлого;
  - 5.5.6 Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагааны орлого гэх мэт.

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:


Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг/



- 5.6 Холбооны орлогыг зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна. Уг орлогоос ноогдол ашиг хуваарилах, аливаа байгууллага, хувь хүнд хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн өмнөөс ямар нэг төлбөр хийх, Монгол улсын Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл болон хувиараа нэр дэвшигчид хандив өргөх зэргийг хориглоно. Түүнчлэн Удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирлаас Холбооны эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн ба аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

#### **ЗУРГАА. Холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах**

- 6.1 Холбоо энэхүү дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан бөгөөд цаашид үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагагүй буюу шинэ, өөр зорилт дэвшүүлэн, өөрчлөн байгуулахаар бол татан буулгах буюу өөрчлөн байгуулж болно. Татан буулгах буюу өөрчлөн байгуулах асуудлыг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн олонхи (2/3) -ийн саналаар шийдвэрлэнэ.
- 6.2 Холбоо нь дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулж, хууль, тогтоомж зөрчсөнийг шүүхээс тогтоож, албадан татан буулгах шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсноор татан буугдана.
- 6.3 Холбоог татан буулгасан буюу өөрчлөн байгуулсан шийдвэрийг 21 хоногийн дотор нийтэд мэдээлж, Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
- 6.4 Холбоо татан буугдсан тохиолдолд холбогдох төлбөр тооцоог барагдуулсны дараа түүний эзэмшлийн эд хөрөнгийг ижил зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, эсвэл зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

#### **ДОЛОО. Бусад зүйл**

- 7.1 Энэхүү дүрэм нь Бүх гишүүдийн хурлаар гишүүдийн олонхийн (2/3) –ийн саналаар батлагдсан бөгөөд батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 7.2 Холбооны дүрэмд Удирдах зөвлөлийн гишүүдийн 80%-ийн саналаар, бүх гишүүдийн 2/3-оос доошгүй гишүүдийн саналаар, Төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэх шийдвэр гарсан, хууль эрхзүйн орчинд өөрчлөгдсөн тохиолдолд энэ дүрмийн дагуу өөрчлөлт оруулж болно.
- 7.3 Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

--- 0 -- 0 ---

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

/Б.Бямбажав /

/Д.Гантулга /

/С.Алтанцэцэг/

